

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-8

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонголд нэр дэвшигчийг сонгох тухай/	4-7
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонголын тов тогтоох, сонгогч даргалагч сонгох, сонголын бэлтгэл хангахтай холбоотой дэг батлах тухай/	7-8

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 27-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 32 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Баттулга, Х.Баасанжаргал, Л.Мөнхбаатар, О.Номинчимэг, С.Одонтуяа, Да.Цогтбаатар, Б.Энхбаяр.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголд нэр дэвшигчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нэр дэвшигчдийн талаар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.6-д заасны дагуу нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 1.Чимэдийн Сайнбилэгийг Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Лхагважавын Төр-Одыг Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 12
Бүгд: 13
7.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Зандаръяагийн Баянмөнхийг Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 12
Бүгд: 13
7.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Соронзонболдын Халиунааг Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 15 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагч сонгох, сонсголын бэлтгэл хангахтай холбоотой дэг батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагч сонгох, сонсголын бэлтгэл хангахтай холбоотой дэг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагч сонгох, сонсголын бэлтгэл хангахтай холбоотой дэг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 24 минут үргэлжилж, 22 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 56 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 15 цаг 32 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ХЗБХ-ны 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирц 54.5 хувьтай байна. Ирсэн гишүүдийг танилцуулъя. Дамдины Цогтбаатар, Жуковын Алдаржавхлан, Энхтайваны Бат-Амгалан, Дашдондогийн Ганбат, Батжаргалын Заяабал, Мөнхтөрийн Нарантуяа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Лувсансүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр ирц бүрдсэн байна аа. Ингээд Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

1.Нэр дэвшигчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

2.Байнгын хорооны тогтоолын төсөл Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагч сонгох, сонсголын бэлтгэл хангахтай холбоотой дэг батлах тухай байгаа.

Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна аа. Тэгвэл хэлэлцэх асуудалдаа орно. Хэлэлцэх асуудал 1 дүгээр асуудал Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ХЗБХ-ны 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 8 дугаар тогтоолыг баталж, Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн бүртгэлийг олон нийтэд 14 хоногийн хугацаанд зарласан. Бүртгэлийн хугацаанд тус албан тушаалд нэр дэвших хүсэлт материалаа 4 хүн ирүүлсэн байгаа.

Иймд хууль тогтоомжид заасны дагуу 2 нэр дэвшигчийг сонгох асуудлыг хэлэлцэж эхэлье ээ.

Өөрөөр хэлбэл 4 хүнээс бид нар 2 хүнийг нь өнөөдөр сонгох байгаа. Тэгээд тэрийг дараагийн Байнгын хороон дээр тэр 2 хүний асуудлыг оруулж ирж энэ сонсголыг нь явуулна гэсэн үг. 2 нэр дэвшигчийг тодруулж. Ингээд Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшихээр бүртгүүлсэн иргэдийг танилцуулъя.

Би бүртгэлийн дарааллаар танилцуулъя. Хүн тус бүрээр уншиж танилцуулна аа. Энд ямар болзол шаардлага байгааг юуны өмнө эхлээд танилцуулчихъя.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид тавих болзол шаардлага.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д зааснаар Хяналтын зөвлөлийн дарга гишүүнээр Эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн ажлын дадлага туршлагатай, ёс зүйн хувьд төлөвшсөн Монгол Улсын иргэнийг томилно. Тэгээд Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид хориглох зүйл гэдэг дээр бол Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5-д зааснаар Хяналтын зөвлөлийн дарга гишүүнээр улс төрийн албан хаагч, улс төрийн намын удирдах албан тушаалтан ҮХЦ-ийн гишүүн бүх шатын шүүхийн шүүгч, прокурор, хорооны дарга, гишүүн болон ажлын албаны удирдах гүйцэтгэх албан тушаалтныг томилохыг хориглоно өгсөн байгаа. ингээд нэр дэвшихээр бүртгүүлсэн 4 иргэн нь эдгээр болзлийг хангаж байгаа.

Ингээд 4 нэр дэвшигчийг би нэрээр нь уншаад танилцуулаад явчихъя. Нэр дэвшигч Ч.Сайнбилиг бүрдүүлсэн материал нь бүрэн байгаа. Мэргэжил 1993-1994 онд МУИС-ийн Эдийн засгийн дээд сургуулийг төгссөн байна. Тэгээд эдийн засагт мэргэжилтэй юм байна. 2006-2008 онд Калифорнийн их сургуулийг магистр зэрэгтэйгээр дүүргэсэн байна. 1997-2008 онд ажилласан байдал нь бол 1997-2008 онд Монгол шуудан банк диллер, 2013-2016 онд Хадгаламж даатгал корпорацын дэд захирал, 2014-2022 онд Тээвэр, хөгжлийн банк, Санхүү эрхэлсэн захирал.

2.Төр-Од материалаа бүрэн бүрдүүлж өгсөн байгаа.

Мэргэжил 1992-1997 онд Энэтхэг улсын Хууль зүйн их сургууль, Эдийн засаг, улс төрийн бакалавр, 2005-2006 онд Лондоны их сургуульд Дорно дахины Африк судлалын хууль зүйн магистр, 2008 оноос МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант гэсэн мэргэжлийн байдал нь ийм байна.

1997-1999 онд Хууль зүйн яаманд Хууль төсөл боловсруулах хэлтэст мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, 1999-2005 онд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Засаглалын хөтөлбөрийн удирдагч, шинжээч, референт 2005-2011 онд Хас банк, Тэнгэр санхүүгийн нэгдэл, Лондон дахь төлөөлөгч, зөвлөх, Тамгын газрын захирал, Хууль зүй хянан нийцүүлэх газрын захирал, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Монголын эдийн засгийн форумын зохицуулагч, Ерөнхий захирал, 2012 онд Монголбанкны холбооны зөвлөх, гүйцэтгэх захирал бөгөөд ЕНБД, 2012 ондоо ийм албан тушаал хашиж байсан байна. Мөн 2012 онд ЗГХЭГ-ын Ерөнхий сайдын ажлын албаны Ерөнхий сайдын зөвлөх, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хууль зүйн яам, Хууль зүйн асуудал хариуцсан шадар туслах бөгөөд Хууль зүйн сайдын зөвлөх, 2014-2017 онд АТГ-ын дэргэдэх олон нийтийн зөвлөлийн ерөнхийлөгчөөс томилсон гишүүн, дарга, 2016-2018 онд НЗДТГ-ын НИТХ, НЗД-ын зөвлөх, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын зөвлөх 2016-2018 онд байсан байна. 2017-2019 онд олон улсын нээлттэй засгийн түншлэлийн олон улсын удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд Ази Номхон далайн бүс нутгийн төлөөлөгч, 2019 онд АСЕМ, Ази Европын ард түмний форум олон улсын зохион байгуулах хорооны байнгын гишүүн, 2020-2024 онд

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө монополын эсрэг газрын Засгийн газраас томилсон гишүүн. 2021-2027 онд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Улсын Их Хурлаас томилсон гишүүн, 2024 оны 4 дүгээр сараас 2024 оны 11 дүгээр сард Монгол Улсын ЗГХЭГ-ын Ерөнхий сайдын ажлын алба, Ерөнхий сайдын Авлигын эсрэг бодлого хариуцсан зөвлөх, 2024 оны 11 дүгээр сараас Монгол Улсын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын удирдах зөвлөлийн дарга бөгөөд Ерөнхийлөгч гэсэн ийм албан тушаалтай хүн байна.

3.3.Баянмөнх материалаа бүрэн өгсөн. Мэргэжил 1999-2004 онд ШУТИС-ийн академич Бизнесийн удирдлагаар, 2019-2021 онд Япон улсын Саятамагийн Их сургуульд Эдийн засгийн магистр, 2005-2006 онд Сангийн яаманд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газарт мэргэжилтэн, 2006-2009 онд Сангийн яаманд ТЗУГ-т мэргэжилтэн, 2009-2012 онд Сангийн яаманд Дотоод аудит хяналт, шинжилгээ, үнэлгээний газарт ахлах мэргэжилтэн, 2012-2019 онд Төрийн захиргааны удирдлагын газарт ахлах мэргэжилтэн.

4.С.Халиунаа материалаа бүрэн өгсөн. Мэргэжил 2001-2005 онд МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийг Эрх зүйчээр төгссөн. 2020 онд Кардиф Метрополитан Университи бизнесийн удирдлагын магистр. 2014 онд Хүүхдийн төлөө үндэсний газар, 2014-2016 онд АПУ компанийн хуулийн зөвлөх, 2016-2020 онд Ард санхүүгийн нэгдэл ХХК-ийн Комплайнс хариуцсан захирал, 2021 оноос Гранд Лекс Партнерс ХХК-ийн гүйцэтгэх захирал хүн байна.

Ийм хүмүүс нэр дэвшсэн байна. Энийг ингээд би та бүгдэд уншиж танилцууллаа. Өнөөдөр хийх ажил бол энэ хүмүүс өөрсдөө биечлэн оролцохгүй. Бид нар зөвхөн материалтай нь танилцаад ХЗБХ-ндоо сонсгол хийхээр орж ирэх 2 хүнээ сонгоно гэсэн үг. Тэгээд дараа нь тэрний дараа нөгөө сонгосон 2 хүн маань өөрөө ирж оролцох ийм зохицуулалттай байгаа.

Энд эрх зүйч гишүүддээ нэг зүйл хэлмээр байна. Одоо энэ юу чинь нөгөө шинэ хууль батлагдсанаас хойш энэ хяналт шалгалтын тухай шинэ хууль батлагдсанаас хойш ингээд анхны ийм сонгон шалгаруулалт явагдаж байна л даа. Тэгээд энэ дээр бол эргэж харах, сайжруулах юмнууд бол үнэхээр хууль дээр байна шүү. Тэгэхгүй бол одоо өнөөдөр хэдүүлээ Байнгын хороогоороо хүн хэлэлцчихээд дараа нь Байнгын хороогоороо дахиад энийгээ хэлэлцэж санал хураах гэж байгаа байхгүй юу. Тэгэхлээр одоо байгаа хуулиа л барьж явахаас өөр арга байхгүй. Гэхдээ энэ хууль чинь бол бодит байгаа байдал нь нэг иймэрхүү байдалтай байна. Ингээд иргэдийг би танилцуулсан байгаа. Ингээд Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшихээр бүртгүүлсэн иргэдийг танилцуулж дууслаа.

Энэ дээр та нар маань өөрсдөө танилцсан байгаа юу?

Санал хураалт.

Ингээд хүн бүрээр нь явуулъя. Тэгээд дэгийн тухай журмаараа л өөрөөр хэлбэл саналууд хүчин төгөлдөр болоод явна гэсэн үг. Ингээд санал хураалтыг бүртгүүлсэн иргэдийн дарааллаар явуулъя.

1.Чимэдийн Сайнбилигийг Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээр сонгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Байгаа байлгүй дээ материал тэр өгсөн материал.

Чимэдийн Сайнбилигийг Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээр сонгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

61 хувиар санал дэмжигдлээ.

Лхагважавын Төр-Одыг Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээр сонгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

13 хувиар санал дэмжигдсэнгүй.

3.Зандаръяагийн Баянмөнхийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээр сонгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

13 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Соронзонболдын Халиунааг Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээр сонгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

69.2 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд энэ санал хураалтын дүнг танилцууллаа.

15.51 цагт

Дараагийн асуудалдаа оръё. Ганцхан асуудал маш хурдан би хэлэлцээдэхье. Тогтоолын төслийг та нарт тараасан байгаа.

Тогтоолын төслийг урьд нь би та бүгдтэй ярьж байсан. Энэ тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Асуулт үг хоёроо ер нь хамт явуулчихъя. Энэ нөгөө энэнтэйгээ холбогдсон 14-нд сонсголоо явуулах гээд байна шүү дээ. Тийм. Санал, үг хэлэх гишүүд алга байна аа.

Ингээд үг хэлж, хариулт авч дууслаа.

Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагч сонгох, сонсголын бэлтгэл хангахтай холбоотой дэг батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа. 69.2 хувиар санал дэмжигдлээ. Ингээд тогтоол батлагдлаа. Байнгын хорооны тогтоолыг та бүхэнд уншаад танилцуулчихъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол

2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр дугаар Улаанбаатар хот

Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагч сонгох, сонсголын бэлтгэл хангахтай холбоотой дэг батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, 30.3. 30.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, 131 дүгээр зүйлийн 131.1 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх томилгооны сонсголыг 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар ХЗБХ-ны дарга Цогтбаатарыг сонгосугай.

3. Нэр дэвшигчээс асуулт асуух саналыг цахимаар болон шуудангаар хүлээн авах сонсголд оролцох, ажиглах иргэний хуулийн этгээдийн хүсэлтийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хүлээн авах хугацааг 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 15 цаг хүртэл тогтоосугай.

Нэр дэвшигчийн сонсголын тайланг 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гаргах томилгооны сонсголын зарыг нийтэд мэдээлэх, холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахыг Хууль зүйн байнгын хороо Цогтбаатарт даалгасугай.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар.

Танилцуулж дууслаа. Ингээд өнөөдөр хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

Гишүүддээ ирц бүрдүүлж ирж оролцсонд талархал илэрхийлж байна аа.

15.56 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА